



Огноо: 2020 оны 06 дугаар сарын 22

**СЕРВЕР КОМПЬЮТЕРЫН НӨӨЦЛӨЛТ ХИЙХ ПРОГРАММ ХУДАЛДАН АВАХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр: СЕРВЕР КОМПЬЮТЕРЫН НӨӨЦЛӨЛТ ХИЙХ ПРОГРАММ
ХУДАЛДАН АВАХ**

Төслийн дугаар: ҮАГ-20/018-2

**Улаанбаатар хот
2020 он**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020 оны 06 дугаар сарын 22-ны өдөр

Үндэсний Аудитын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **ҮАГ-20/018-2** дугаартай **“Сервер компьютерын нөөцлөлт хийх программ худалдан авах”** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Үнийн саналыг www.tender.gov.mn сайтаар 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 цаг 30 минутаас өмнө ирүүлнэ.

Үнийн саналыг 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 09 цаг 00 минутад нээнэ.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3
Засгийн газрын IV байр, 04 дүгээр давхар, 403 тоот өрөө
Үндэсний Аудитын газар
Утас: 32 98 70

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгөөр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

<p>ТӨӨЗ-ны холбогдох заалт</p>	<p align="center">Шалгуур үзүүлэлт</p>
<p>Тендер шалгаруулалтын нэр: Сервер компьютерын нөөцлөлт хийх программ худалдан авах Тендер шалгаруулалтын дугаар: ҮАГ-20/018-2</p>	
<p>ТӨӨЗ 1.1</p>	<p>1.Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг ирүүлнэ, 2.Үйлдвэрлэгч байгууллагын Монгол Улс дахь албан ёсны борлуулагч, засвар үйлчилгээ үзүүлэх эрхтэйг нотолсон гэрчилгээний хуулбар. /Нотариатаар баталгаажуулан, баталгаат орчуулгаар орчуулан баталгаажуулж ирүүлэх/ 3.Татварын ерөнхий газрын www.etax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолтыг ирүүлэх ба хуудасны доод хэсэгт байрлах тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаарыг гаргацтай байхаар ирүүлнэ. 4.Харьяа дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тухай тодорхойлолт, 5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт 6.Хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тухай харилцагч банкны тодорхойлолтыг улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан банк тус бүрээс ирүүлнэ.</p>
<p>ТӨӨЗ 2.</p>	<p>2.1. Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Тендерийг 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 цаг 30 минутаас өмнө системд ирүүлнэ.</p> <p>2.2. Нээлтийг 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 09 цаг 00 минутад Үндэсний Аудитын газрын 403 тоот өрөөнд нээнэ.</p> <p>2.3. Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна.</p> <p>Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</p> <p>Баримт бичгүүд нь Монгол хэлнээс бусад хэл дээр байгаа тохиолдолд баталгаат орчуулгын товчоогоор орчуулга хийлгэн тухай бүрд хавсарган ирүүлнэ.</p> <p>Анхааруулга: УИХ-ын 2019.03.22-ны өдрийн чуулганы хуралдаанаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөж эхэлсэн бөгөөд уг хуулийн 55 дугаар зүйлийн 55.9-д “Тендерт оролцогчдын гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ хуулийн 20 дугаар зүйлийн 20.7.3-т заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгох дээд хэмжээ 20 000 000 /хорин сая/ төгрөгөөс хэтрэхгүй. Гомдлыг үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн бол тендерийн баталгааг буцаан олгоно” гэж заасан тул тендерт оролцогч тухайн төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийн шаардлагыг хангаж буй эсэх, нотлох баримтуудыг бүрэн гүйцэд бэлдсэн эсэхээ сайтар нягталж үзсэний</p>

	<p>үндсэн дээр тендер шалгаруулалтад оролцож байхыг хүсье. Учир нь тендер шалгаруулалтын үр дүнг үл зөвшөөрч Сангийн яаманд гаргасан гомдол “үндэслэлгүй” гэж шийдвэрлэгдсэн тохиолдолд тендерийн баталгааг улсын орлого болгох эрх зүйн зохицуулалт 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж байна.</p>										
<p>ТӨӨЗ 3.</p>	<p>Тендерт оролцогч эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үнийн саналын маягтын дагуу дагуу бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ, 2. Бараа нийлүүлэлтийн хуваарь, холбогдох үйлчилгээний жагсаалт болон гүйцэтгэлийн хуваарийг бэлтгэж ирүүлнэ, 3. Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 он туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээ, хүлээлцсэн актын хуулбар, захиалагчийн тодорхойлолт 2-оос доошгүй/; <table border="1" data-bbox="432 674 1453 808"> <thead> <tr> <th data-bbox="432 674 496 757">№</th> <th data-bbox="496 674 687 757">Гэрээний нэр</th> <th data-bbox="687 674 1102 757">Захиалагч байгууллагын нэр, хаяг, утас</th> <th data-bbox="1102 674 1294 757">Төсөвт өртөг</th> <th data-bbox="1294 674 1453 757">Дууссан хугацаа</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="432 757 496 808"></td> <td data-bbox="496 757 687 808"></td> <td data-bbox="687 757 1102 808"></td> <td data-bbox="1102 757 1294 808"></td> <td data-bbox="1294 757 1453 808"></td> </tr> </tbody> </table> <ol style="list-style-type: none"> 4. Тусгай зөвшөөрөл шаардахгүй. 5. Нийлүүлэгч нь нийлүүлж буй бараа материалын үйлдвэрлэгчийн сертификат, ашиглалтын заавар, каталог зураг зэргийг ирүүлнэ 6. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 оны аль нэг жилд тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байх. <p>Програм хангамжийн лиценз нийлүүлсэн туршлагыг тооцно.</p> <ol style="list-style-type: none"> 7. Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 3 жилийн (2017, 2018, 2019 он) дундаж борлуулалтын орлогын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн 50 хувиас багагүй байх. 8. Нийлүүлэгч нь суурилуулалт, угсралтыг хийх албан ёсны сургалтад хамрагдсан, сертификаттай 2-оос доошгүй инженер, техникийн ажилтантай байх, ажилтны диплом, сертификатын хуулбарыг ирүүлэх. 9. Тоног төхөөрөмжөө үйлдвэрлэгчээс шууд нийлүүлж, нийлүүлсний дараах техникийн тусламжийг гуравдагч байгууллагаар дамжуулахгүйгээр үйлдвэрлэгчээс шууд авч захиалагчид нийлүүлэхийг баталсан албан бичиг ирүүлэх. 10. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолтыг ирүүлэх ба хуудасны доод хэсэгт байрлах тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаарыг гаргацтай байхаар ирүүлнэ. Тодорхойлолт нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна, 11. Баталгаат засварын хугацаа 12 сар буюу 1 жилээс багагүй байх шаардлагатай ба албан бичгээр баталгаажуулан мэдэгдэл ирүүлнэ. 12. Тоног төхөөрөмжийн баталгаат хугацаа дууссаны дараа сэлбэг нийлүүлэх боломжтойг баталсан албан бичиг ирүүлэх 13. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх. 	№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, утас	Төсөвт өртөг	Дууссан хугацаа					
№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, утас	Төсөвт өртөг	Дууссан хугацаа							

	<p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл [1] болон [2] дахь заалтын нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны/ 2. Арилжааны банкны зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт /Банкны судлан үзэж зээл олгох боломжтой гэсэн тодорхойлолтыг үнэлгээнд харгалзахгүй/. 3. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг Сангийн сайдын 2015 оны 343 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн загвар”-ын 3.2.2 /е/-д “Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө = Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө + Санхүүгийн хөрөнгө + Дансны авлага гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэнэ” гэж заасны дагуу тодорхойлно.
ТӨӨ3.4	<p>Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулахгүй тогтмол байна. Тендерийн валют: төгрөг байна.</p>
ТӨӨ3.5.	<p>Нийлүүлэх бараа техникийн шаардлагыг бүрэн хангасан байна. Техникийн үзүүлэлт, шаардлага зөрсөн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p>

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
2. БАРААНЫ ЖАГСААЛТ БА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ
3. ХОЛБОГДОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВААРЬ

1. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Тендер шалгаруулалтын нэр: **Сервер компьютерын нөөцлөлт хийх программ худалдан авах**

Тендер шалгаруулалтын дугаар: **ҮАГ-20/018-2**

№	Техник хангамжийн нэр	Тоо	Тавигдах шаардлага, Техникийн үзүүлэлт, тодорхойлолт
1	Veeam backup & replication for Enterprise edition	1	Хувилбар: Veeam backup & replication for Enterprise edition per Socket Процессорын тоо: 2 sockets

2.БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Тендер шалгаруулалтын нэр: **Сервер компьютерын нөөцлөлт хийх программ худалдан авах**

Тендер шалгаруулалтын дугаар: **ҮАГ-20/018-2**

Нэр	Тодорхойлолт	Хэмжих нэгж, тоо	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
				Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
Veeam backup & replication for Enterprise edition	Хувилбар: Veeam backup & replication for Enterprise edition per Socket Процессорын тоо: 2 sockets	ширхэг, 1	Үндэсний Аудитын газар	Бараа нийлүүлэх 5 хоног	Бараа нийлүүлэх 10 хоног	

3.ХОЛБОГДОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ БА ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВААРЬ

Тендер шалгаруулалтын нэр: **Сервер компьютерын нөөцлөлт хийх программ худалдан авах**

Тендер шалгаруулалтын дугаар: **ҮАГ-20/018-2**

1	2	3	4	5	6
Нэр төрөл	Үйлчилгээний талаарх тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Үйлчилгээг гүйцэтгэх газар болон ажлын талбай	Үйлчилгээг гүйцэтгэж дуусгах огноо
Veeam backup & replication for Enterprise edition	Хувилбар: Veeam backup & replication for Enterprise edition per Socket Процессорын тоо: 2 sockets	1	ширхэг	Үндэсний Аудитын газар	Барааг хэрэглэхэд бэлэн байдлаар хүлээлгэн өгнө.

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 12 сар ба түүнээс дээш байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)

Үндэсний Аудитын газар
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр, 4 дүгээр давхар, 403 дугаар тоот
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
 - 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
 - 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээЭнд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
 - 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа **12 сар ба түүнээс дээш** байна.
4. Төлбөр (ГЕН – 7)
 - 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)
 - 9.1. Алданги оногдуулах хувь: **Хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0,01 хувь** байна.

Алдангийн нийт дүн: **Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй** байна.
6. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах
 - 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч 30 хоногийн дотор бүрэн барагдуулна.
7. Маргааныг шийдвэрлэх
 - 11.1. Захиалагч болон нийлүүлэгч талуудын хооронд гарсан маргааныг Монгол улсын хуулийн дагуу шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг¹;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;

¹ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]